# ЦАХИМ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ Ч.БОЛОР-ЭРДЭНИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.. “НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙН СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨЛТ, БАРИМТЛАХ БОДЛОГО, ЧИГЛЭЛ, ЖУРАМ, СТАНДАРТЫН СУДАЛГААНД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, САЙЖРУУЛАХ САНАЛ БОЛОВСРУУЛАХ”** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** *Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний № 1.* Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн төслийг холбогдох газар нэгжтэй хамтран боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх | Хүргүүлсэн баримт бичгийн тоо 1 | Олон Улсын судалгаа хийгдсэн. | Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн төсөл, холбогдох бусад баримт бичиг боловсруулагдаж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Тус ажлыг 2024 онд хийхээр Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгасан.<br><br>**Хэрэгжилт хангагдаагүй шалтгаан:**<br>1. Ерөнхий сайдын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 206 дугаар захирамжаар байгуулагдсан эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд систем хооронд мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх асуудлыг судалж, санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх Дэд ажлын хэсгийг ЦХХХС-ын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/04 дугаар тушаалаар байгуулсантай холбогдуулж, эрүүл мэндийн салбарын холбогдох албан хаагчидтай хамтран Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасан “Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам”-ыг боловсруулж, Засгийн газрын 2024 оны 100 дугаар тогтоолоор, мөн зүйлийн 8.10 дахь хэсэгт заасан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах | 01.15-03.30 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шаардлагыг тогтоох, үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам"-ын төслийг боловсруулж Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А-138/А-37 хамтарсан тушаалаар тус тус батлуулсан.<br><br>Мөн "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам"-ын төслийг боловсруулах явцад хийсэн нөлөөллийн шинжилгээ болон танилцуулгыг бэлтгэн Эрүүл мэндийн яаманд 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 01/1203 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | | |
| | ***Дэд арга хэмжээ 1.1.1.*** Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн талаарх нөхцөл байдлын судалгаа хийнэ. | Судалгааны тоо 1 | 0 | Төсөл боловсруулах практик үндэслэл боловсруулагдсан байна. | 1. Европын холбоо болон Олон Улсын эдийн засаг, хөгжлийн нийгэмлэг (OECD)-ээс гаргасан эрх зүйн баримт бичиг (20 гаруй)-ийг судалсан.<br><br>2. Алсын хараа 2050, түүнийг хэрэгжүүлэх 2030, Шинэ сэргэлтийн бодлого, 5 жилийн үндсэн чиглэл, ЗГҮАХ 2020-2024, Улсын хөгжлийн төлөвлөгөө 2024, Цахим үндэстэн дунд хугацааны бодлого, Яамны Стратеги төлөвлөгөө болон ЗГХЭГ-ын даргын 100 дугаар тушаалд туссан арга хэмжээний төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтийг судалсан.<br><br>3.Салбарын хуулиудаас дэд бүтцийн төлөвлөлт, зохиуулалттай холбоотой заалтуудыг нэгтгэн гаргасан.<br><br>4. Дээрх судалгааг нэгтгэн танилцуулга бэлтгэж, төлөвлөлт болон журмын төслийн бүтцийн төлөвлөгөөг боловсруулсан. | 01.15-02.01 | 100 |
| | ***Дэд арга хэмжээ 1.1.2.*** Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий | Боловсруулагдсан баримт бичгийн | Төслийн эхний хувилбар | Төслийн эцсийн хувилбар болон саналын товъёг | Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн төслийг боловсруулсан. | 02.05-03.10 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөлтийн төслийг боловсруулж, холбогдох газруудаас санал авч нэгтгэнэ. | тоо-2 | боловсруулагдсан. | боловсруулагдсан байна. | | | |
| | ***Дэд арга хэмжээ 1.1.3.*** Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн төслийн нөлөөллийн шинжилгээг боловсруулна. | Боловсруулсан баримт бичгийн тоо-2 | 0 | Нөлөөллийн шинжилгээний төсөл, түүний танилцуулга боловсруулагдсан байна. | Хийгдээгүй. | 03.15-03.22 | 0 |
| | ***Дэд арга хэмжээ 1.1.4.*** Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн төслийн танилцуулга, холбогдох бусад мэдээллийг боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх хүсэлтийн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | Баримт бичгийн тоо-4 | 0 | Баримт бичгийн төсөл, танилцуулга, саналын товъёг, хүсэлт хүргүүлэх бичгийн төсөл боловсруулагдсан байна. | Хийгдээгүй. | 03.25-03.29 | 0 |
| 2. | **Арга хэмжээ 1.2.** *Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний № 2.* Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төслийг холбогдох газар нэгжтэй хамтран боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх | Хүргүүлсэн баримт бичгийн тоо 1 | 0 | Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төсөл, холбогдох бусад баримт бичиг боловсруулагдаж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Тус ажлыг 2024 онд хийхээр Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгасан.<br><br>**Хэрэгжилт хангагдаагүй шалтгаан:**<br>1. “Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон) ашиглалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх, туршилтын бүс байгуулах талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.<br><br>2. Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудсыг ашиглах журам"-ыг эцэслэн боловсруулж, Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2024 | 01.15-03.30 | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | оны 12 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. | | |
| ***Дэд арга хэмжээ 1.2.1.*** Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төслийг боловсруулж, холбогдох газруудаас санал авч нэгтгэнэ. | Боловсруулагдсан баримт бичгийн тоо-2 | Төслийн эхний хувилбар боловсруулагдсан. | Төслийн эцсийн хувилбар болон саналын товъёг боловсруулагдсан байна | 1. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн туршилтын бүс байгуулах талаар холбогдох судалгаа хийх, тус бүсийг байгуулахад шаардлагатай дүрэм, журмын төсөл болон үйл ажиллагаанд нэвтрүүлэх санал боловсруулж, туршилтын бүсийн байршлыг тодорхойлох үүрэг бүхий "Ажлын хэсэг"-ийг 2024 оны 09 дүгээр сард байгуулж, нисгэгчгүй нисэх төхөөрөмжтэй холбоотойгоор хийгдсэн судалгаа болон холбогдох хууль эрхзүйн баримт бичгийн судалсан.<br>2. Хонхорт байрлах 140 га талбайд хүнгүй агаарын хөлөг, хүнгүй агаарын хөлгийн систем туршихад цахилгаан соронзон оронгийн нөлөөлөл үүсэх боломжтой эсэх дүгнэлтийг Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран хийсэн.<br>3. ИНЕГ-тай хамтран нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн туршилтын бүс байгуулах боломжтой байршлын талаарх судалгааг хийж, өндрийн хязгаартай болон өндрийн хязгааргүй нийт 6 байршлын мэдээллийг гаргаж, тус газрын эзэмшлийн мэдээллийг гаргуулахаар 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 03/848 дугаартай албан бичгийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлсэн.<br>3."Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон) ашиглалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх, туршилтын бүс байгуулах талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан, Засгийн газрын 21 сайдаас санал авч, улмаар Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. | 02.05-03.10 | 100 |
| ***Дэд арга хэмжээ 1.2.2.*** Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төслийн | Боловсруулсан баримт бичгийн тоо-2 | 0 | Нөлөөллийн шинжилгээний төсөл, түүний танилцуулга | Хийгдээгүй. | 03.15-03.22 | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нөлөөллийн шинжилгээг боловсруулна. | | | боловсруулагдсан байна. | | | |
| | ***Дэд арга хэмжээ 1.2.3.*** Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төслийн танилцуулга, холбогдох бусад мэдээллийг боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх хүсэлтийн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | Боловсруулсан баримт бичгийн тоо-4 | 0 | Баримт бичгийн төсөл, танилцуулга, саналын товъёг, хүсэлт хүргүүлэх бичиг боловсруулагдсан байна. | Хийгдээгүй. | 03.25-03.29 | 0 |
| 3. | **Арга хэмжээ 1.3.** Салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, хариуцсан чиг үүргийн хүрээнд санал боловсруулна. | Нэмэлт, өөрчлөлт оруулах хууль, тогтоомжийн тоо 2 | 0 | Боловсруулж хүргүүлсэн саналын тоо 1 | ЦХБХЗГ-ын хариуцах асуудлын хүрээнд болон өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд Харилцаа холбооны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Хуулийн хэлтэст хүргүүлсэн. | 01.15-12.15 | 100 |
| | ***Дэд арга хэмжээ 1.3.1.*** Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, хууль, эрх зүйн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ. | Боловсруулсан саналын тоо 1 | 0 | Боловсруулж хүргүүлсэн саналын тоо 1 | 1. Сайдын 2024 оны А/13 тушаалаар байгуулагдсан "Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төсөл боловсруулах, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр төслийг хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, дараах ажлыг хийж гүйцэтгэсэн:<br>Эстони, Турк, Солонгос Улсын Харилцаа холбооны тухай хуулийн орчуулга болон Зөвшөөрлийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай, НМИТБТ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудыг судалж, хуульд оруулах нэр томъёоны тайлбар, мэдээллийн сүлжээ, салбар хоорондын уялдаатай холбогдох зохицуулалтад санал боловсруулж, ажлын хэсгийн хуралд танилцуулсан. Мөн тус хуульд нэмэлт | 01.05-03.25 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | өөрлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг Хуулийн хэлтсийн ахлах шинжээч Б.Солонготой хамтран боловсруулж, салбарын 10 гаруй байгууллагын төлөөллийг оролцуулсан хуулийн хэлэлцүүлгийг 2024 оны 01 дүгээр сарын 05 өдөр зохион байгуулсан. Мөн 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт өөрлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг (олон нийтийн)-ийн зохион байгуулалтын багт орж, оролцогчдоос ирүүлсэн саналыг нэгтгэн, Хуулийн хэлтэст хүргүүлсэн. | | |
| ***Дэд арга хэмжээ 1.3.2.*** Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж, хууль, эрх зүйн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ. | Боловсруулсан саналын тоо 1 | 0 | Боловсруулж хүргүүлсэн саналын тоо 1 | Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/21 дүгээр тушаалаар байгуулагдсан "Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний хуулиар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтад дүн шинжилгээ хийх, тухайн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах" үүрэг бүхий Дэд ажлын хэсэгт орж, дараах ажлыг хийж гүйцэтгэсэн:<br>Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 2023 оны "Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, хуулиар тусгайлан эрх олгосон заалтын судалгааны дүн, цаашид авах арга хэмжээний тухай" 48 дугаар тэмдэглэл, Ерөнхий сайдын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2023 оны 191 дүгээр захирамж, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны "Дэд ажлын хэсэг байгуулах тухай" А/21 дүгээр тушаалын дагуу Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, түүний хүрээнд батлагдан гарсан хэм, хэмжээ тогтоосон актад дүн шинжилгээ хийж, эрх олгосон 9 заалтыг хүчингүй болгож, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар байгуулагдсантай холбогдуулж эрх олгосон 2 заалтын чиг үүргийг шилжүүлж, | 01.15-12.15 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинээр 5 хэсэг, 17 заалт нэмж, 17 хэсгийг өөрчлөн (нэмж найруулсан 8, хасаж найруулсан 4, өөрчлөн найруулсан 5) найруулж, 1 заалтын дугаарыг өөрчилж, Нийтийн мэдээлийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулгыг тус тус боловсруулан, Хуулийн хэлтэст хүргүүлсэн. | | |
| 4. | **Арга хэмжээ 4.** Нийтийн мэдээллийн дэд бүтцийн стратеги, төлөвлөлт, баримтлах бодлого, чиглэлд хариуцсан чиг үүргийн хүрээнд санал боловсруулна. | Боловсруулсан саналын тоо 1 | 0 | ЦХБХЗГ-ын хариуцан хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө Яамны стратеги, төлөвлөгөөнд туссан байна. | Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/49 дугаар тушаалаар байгуулагдсан "Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны Стратеги, төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүнд орж, ЦХБХЗГ-ын газрын хариуцах асуудлын хүрээнд холбогдох саналыг боловсруулан, ажлын хэсгийн 3 удаагийн хуралд танилцуулсан. | 03.13-06.15 | 100 |
| | ***Дэд арга хэмжээ 1.4.1.*** Яамны стратеги төлөвлөгөөнд хариуцсан чиг үүргийн хүрээнд санал боловсруулах, ЦХБХЗГ-ын газрын хариуцах асуудлын хүрээнд холбогдох газруудаас санал авч нэгтгэн, тус асуудлыг хариуцсан нэгжид хүргүүлнэ. | Боловсруулсан саналын тоо 1 | 0 | Хүргүүлсэн саналын тоо 1 | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөө 2024-2028"-д оруулах өнөөгийн байдлын талаарх мэдээллийг ЦХБХЗГ-ын газрын хариуцах асуудлын болон өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд бэлтгэн БТГ-т хүргүүлсэн. Мөн , тус баримт бичгийг боловсруулах аргачлал, загврыг холбогдох албан хаагчдад танилцуулж, "Цахим засаглал" сэдвийн хүрээнд боловсруулагдах мэдээллийг бэлтгэсэн. Түүнчлэн ажлын хэсгийн хуралд тухай бүр оролцож ажилласан. | 01.09-01.09 | 100 |
| **Зорилт 2. "НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТ, АШИГЛАХ ТЕХНОЛОГИЙН ТАЛААР БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ, ЖУРАМ, СТАНДАРТАД СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, САЙЖРУУЛАХ САНАЛ БОЛОВСРУУЛАХ"** | | | | | | | |
| 5. | **Арга хэмжээ 2.1.** *Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний № 5.* Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/18 тушаалаар батлагдсан "Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл | Батлагдсан баримт бичгийн тоо-1 | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны "Журам батлах тухай" А/18, "Ажлын хэсэг байгуулах | Журмыг шинэчлэн батлуулж, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлсэн байна. | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/18 тушаалаар батлагдсан "Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг шинэчлэн боловсруулж, олон нийтээс болон харъяа 4 байгууллагаас санал авч нэгтгэсэн. 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар тус | 04.15-06.15 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | | тухай" A/25 дугаар тушаал батлагдсан | | журмыг батлуулахаар Сайдын тушаалын төсөлд санал авч байна | | |
| | ***Дэд арга хэмжээ 2.1.1.*** Журмын төслийг шинэчлэн боловсруулж, санал авна. | Шинэчлэн батлагдсан актын тоо-2 | 0 | Төслийн шинэчилсэн хувилбар болон саналын товъёг боловсруулсан байна | Тус яамны сайдын "Журам шинэчлэн батлах тухай" тушаалын төсөл, "Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ын төсөл болон "Ажлын хэсгийн бүрэлдэхүүн"-ний төслийг боловсруулж, ЦЗХ, НМДБХ-ийн албан хаагчдад танилцуулж, холбогдох саналыг тусган нэгтгэж, олон нийтээс санал авахаар яамны цахим хуудас (mddc.gov.mn)-т 2024 оны 05 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд байршуулсан. Мөн Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Үндэсний дата төв УТҮГ, И-Монгол Академи УТҮГ болон Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-аас тус тус санал авахаар2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 03/1223 албан бичгээр хүргүүлсэн. | 04.15-06.15 | 100 |
| | ***Дэд арга хэмжээ 2.1.2.*** Журмын төслийн нөлөөллийн шинжилгээг боловсруулж, тус яамны сайдаар баталгаажуулна. | Боловсруулсан баримт бичгийн тоо-1 | 0 | Нөлөөллийн шинжилгээний төсөл, түүний танилцуулга боловсруулагдсан байна | Журмын төслийн нөлөөллийн шинжилгээний төслийг боловсруулж байна. | 06.22-06.28 | 80 |
| | ***Дэд арга хэмжээ 2.1.3.*** Журмыг шинэчлэн батлуулж, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх хүсэлтийг Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлнэ. | Боловсруулсан баримт бичгийн тоо-4 | 0 | Журмыг шинэчлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэх хүсэлтийг ХЗДХЯ-нд хүргүүлсэн байна. | Сайдын тушаалын төсөлд санал авч байна. | 06.28-06.30 | 0 |
| 6. | **Арга хэмжээ 2.2.** Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд бусад | Боловсруулсан саналын тоо 3 | 0 | Саналын дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ эсхүл өөрчлөлт орсон хэм хэмжээний актын тоо 2 | Ерөнхий сайдын 2023 оны 206 дугаар захирамжаар байгуулагдсан "Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд систем хооронд мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх асуудлыг судалж, санал боловсруулан танилцуулах | 01.15-06.11 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| байгууллагын үйл, ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбоотой дүрэм, журам, стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулна. | | | | үүрэг бүхий ажлын хэсэг"-т дэмжлэг үзүүлэх зорилготой тус яамны сайдын 2024 оны А/04 дүгээр тушаалаар байгуулагдсан "Дэд ажлын хэсэг"-ийн 3-р багийн нарийн бичгээр томилогдон дараах ажлыг хийж гүйцэтгэсэн:<br>1. Эрүүл мэндийн тухай хуулийн 8.4 дэх хэсэгт заасан "Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах" журмын төслийг Эрүүл мэндийн яамтай хамтран боловсруулж, 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, 100 дугаар тогтоолоор батлуулсан.<br><br>2. Эрүүл мэндийн тухай хуулийн 8.10 дахь хэсэгт заасан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлагыг тогтоох, үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам"-ын төслийг Эрүүл мэндийн яамтай хамтран боловсруулж, Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны А/138, А/37 хамтарсан тушаалаар батлуулсан.<br><br>3. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-д заасан зарим чиг үүргийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт хариуцуулуулах зорилготой "Ажил хариуцуулах, гэрээ байгуулах эрх олгох тухай" Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын тушаалын төсөл, түүний танилцуулгыг Хуулийн хэлтсийн ахлах шинжээч Б.Солонготой хамтран боловсруулсан. | | |
| ***Дэд арга хэмжээ 2.2.1.*** Бусад байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд | Хамтран ажилласан байгууллагын тоо 2, | 0 | Хамтран ажилласан байгууллагын тоо 1 | Эрүүл мэндийн яам болон түүний харъяа 20 гаруй байгууллагатай хамтран ажилласан. | 01.15-06.11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хариуцсан чиг үүргийн хүрээнд дэмжлэг үзүүлж, дүрэм, журам, стандартад өөрчлөлт оруулахад хамтран ажиллана. | Хэрэгжүүлсэн арга хэмжээ эсхүл өөрчлөлт оруулсан захиргааны актын тоо 3 | 0 | Хэрэгжүүлсэн арга хэмжээ эсхүл өөрчлөлт оруулсан захиргааны актын тоо 2 | Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.10 дахь хэсэгт тус тус заасан журмын төслийг боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгээр томилогдон, нийт 6 удаагийн уулзалт зохион байгуулж, 2 удаагийн хурлын тэмдэглэлийг албажуулж, журмын төсөлтэй холбогдох танилцуулга, материалын төслийг бэлтгэсэн. Мөн журмын төсөлд холбогдох газруудаас санал авч нэгтгэн саналын товъёг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх, хоёр яамны сайдаар актыг баталгаажуулах зохион байгуулалтын ажлыг хариуцан гүйцэтгэсэн. Түүнчлэн тус хуулийн 8.10 дахь хэсэгт заасан журмын төслийн нөлөөллийн үнэлгээ, түүний танилцуулгыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалаар баталсан “Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу боловсруулж, 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 01/1203 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 01.15-06.11 | 100 |
| **Зорилт 3. “НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦЭД ХАМААРАХ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ, ЦАХИМ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНД ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХӨД МЭДЭЭЛЭЛ, АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАХ ХЯНАЛТ ТАВИХ”** | | | | | | | |
| 7. | **Арга хэмжээ 3.1.** *Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний №21.* Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнөх үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт боловсруулж, мэдээлэл хариуцагчид хүргүүлнэ. | Мэдээлэл хариуцагчид хүргүүлсэн зөвлөмж, дүгнэлтийн тоо */ирүүлсэн хүсэлтийн тоогоор/* | 0 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн хэрэгжилтийн тайлан гарсан байна. | Тайлант хугацаанд хүсэлт ирээгүй болно. | 02.01-06.15 | - |
| | ***Дэд арга хэмжээ 3.1.1.*** Мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, хариуцсан чиг үүргийн хүрээнд санал боловсруулах, холбогдох байгууллагуудаас санал авч, нэгтгэнэ. | Боловсруулсан саналын тоо болон нэгтгэн боловсруулсан зөвлөмж, дүгнэлийн тоо */ирүүлсэн хүсэлтийн тоогоор/* | 0 | Зөвлөмж, дүгнэлтийн төсөл боловсруулагдсан байна. */Ирүүлсэн хүсэлтийн тоогоор/* | Тайлант хугацаанд хүсэлт ирээгүй болно. | 02.01-06.15 | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ***Дэд арга хэмжээ 3.1.2.*** Зөвлөмж, дүгнэлтийн төслийг баталгаажуулж, хүсэлт гаргасан мэдээлэл хариуцагчид хүргүүлнэ. | Мэдээлэл хариуцагчид хүргүүлсэн зөвлөмж, дүгнэлтийн тоо */ирүүлсэн хүсэлтийн тоогоор/* | 0 | Мэдээлэл хариуцагчид зөвлөмж, дүгнэлт хүргүүлсэн байна. */Ирүүлсэн хүсэлтийн тоогоор/* | Тайлант хугацаанд хүсэлт ирээгүй болно. | 02.01-06.15 | - |
| 8. | **Арга хэмжээ 3.2.** *Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний № 28.* Төрийн үйлчилгээний нэгдсэн систем ашиглан төлбөр тооцоо хийх шийдэл боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлнэ. | Үйлчилгээ нэвтрүүлсэн эсэх Тийм/үгүй | Тус яамны сайдын 2023 оны А/118 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. | Үйлчилгээ нэвтэрсэн байна. | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр үзүүлэх үйлчилгээний төлбөрийг Төрийн сангийн дэд бүтцийг ашиглан картын бүртгэл үүсгэж, картаар төлбөр төлөх боломжийг бүрдүүлэх зорилгоор Монгол банкны Токен үйлчилгээтэй холболт хийж, Голомт банк, Худалдаа хөгжлийн банктай хамтран системийн туршилт/тестийг бүрэн хийж дуусгасан. Мөн Монгол банкны Токен үйлчилгээний систем (ТҮС)-д Төрийн үйлчилгээний төлбөрийн систем (e-Mongolia.mn-ийн ewallet систем)-ийг холбож, Монгол банк, Сангийн яам хооронд мэдээлэл солилцох, үйлчилгээ нийлүүлэх гэрээ байгуулах шаардлагатай талаар албан хүсэлт явуулахаар ажиллаж байна. | 01.15-06.15 | 80 |
| | ***Дэд арга хэмжээ 3.2.1.*** Төрийн үйлчилгээний нэгдсэн систем ашиглан төлбөр тооцоо хийх шийдэл боловсруулахад холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, шийдлийн санал боловсруулна. | Шийдлийн дагуу системийн туршилт хийгдсэн байна. | Хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулагдсан. | Боловсруулсан саналын дагуу системийн холболтыг хийж, тест хийгдсэн байна. | Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/118 дугаар тушаалаар "Төрийн үйлчилгээний нэгдсэн систем ашиглан төлбөр тооцоо хийх шийдэл боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх зөвлөмж гаргах" үүрэг бүхий ажлын хэсгийн нарийн бичгээр томилогдон дараах ажлыг хийж гүйцэтгэсэн: Төрийн үйлчилгээний төлбөрийн систем (e-Mongolia.mn-ийн ewallet систем)-ийг Монгол банкны TSP (Token service provider) системтэй холбож, Хаан, Голомт, Худалдаа хөгжлийн банкны картыг тестийн орчинд бүртгэх, гүйлгээ гаргах холболт болон цахим хэтэвч (ewallet)-ийг хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбоотой асуудлаар 4 удаагийн уулзалтыг И-Монгол Академи УТҮГ-тай хамтран зохион байгуулсан. | 02.15-5.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ***Дэд арга хэмжээ 3.2.2.*** Шийдлийн дагуу Төрийн үйлчилгээний төлбөрийн систем (e-Mongolia.mn-ийн ewallet систем)-ийг Монгол банкны Токен үйлчилгээний систем (ТҮС)-тэй холбохтой холбогдсон зохицуулалт хийнэ. | Үйлчилгээ нэвтэрсэн байна. | 0 | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia.mn/-ээр үзүүлэх үйлчилгээний төлбөрийг Төрийн сангийн дэд бүтцийг ашиглан картын бүртгэл үүсгэж картаар төлбөр төлөх боломж бүрдсэн байна. | Төрийн үйлчилгээний төлбөрийн систем (e-Mongolia.mn-ийн ewallet систем)-ийг Монгол банкны TSP (Token service provider) системтэй холбох, Монгол банк, Сангийн яам хооронд үйлчилгээ нийлүүлэх гэрээ байгуулах шаардлагатай байгаа талаарх танилцуулга мэдээллийг бэлтгэн Сангийн яам руу "Хамтран ажиллах тухай" 2024 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн 01/1274 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 01/1274 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Тестийн орчинд гүйлгээ амжилттай төлөлт хийгдсэний дараа бодит орчинд нэвтрүүлэх ажил Сангийн яамнаас хамаарч хүлээгдэж байна. 2024 оны байдлаар иргэд төрийн үйлчилгээний төлбөрийг QPAY, SocialPay, MonPay ашиглан төлж байна. | 06.10-06.11 | 90 |
| **Зорилт 4. "ӨӨРИЙН ХАРИУЦСАН АЖИЛ ҮҮРЭГТ ХАМААРАХ АСУУДЛААР УДИРДЛАГЫГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ, УДИРДАХ ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ"** | | | | | | | |
| 10 | ***Арга хэмжээ 4.1.*** Удирдлагыг өөрийн хариуцсан асуудлын чиглэлээр шаардлагатай мэдээллээр хангаж, түүний ажилд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлнэ. | Тухай бүр удирдлагыг мэдээллээр хангаж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлсэн байна. | 0 | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн:<br><br>1. 2024 онд хийх онцлох 5 ажлын талаар мэдээлэл боловсруулж хүргүүлсэн.<br><br>2. Цахим засаглалыг хүн бүрд үр өгөөжтэй болгосноор хүний эрхийн ямар ямар зөрчлөөс урьдчилан сэргийлэх вэ? гэсэн сэдвийн хүрээнд мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн.<br><br>3. Инновац, цахим бодлогын байнгын хорооны гишүүдэд мэдээлэл хийх ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын дэргэ2024 оны "Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 05 дугаар тогтоолын биелэлтийг 6 асуудлын хүрээнд 16 чиглэлийн дагуу боловсруулсан.<br><br>4. Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 01 албан даалгаврын хэрэгжилтийг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөр тасалбар болгон | 01.15-06.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжилтийг яаралтай гарган, 05 дугаар сарын 01-ний өдөр Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх яаралтай үүрэг даалгавар ирүүлсний дагуу холбогдох 4 заалтын хүрээнд мэдээлэл нэгтгэж, ТЗУГ-т тайлан хүргүүлсэн.<br><br>5. Тус яамнаас Монгол Улсын Засгийн газрын 2021-2023 онд хэрэгжүүлсэн онцлох ажлын товхимолд оруулах мэдээллийг нэгтгэн боловсруулж, албан бичгээр ирүүлсэн форматад оруулж 2024.01.22-ны өдрийн 03/137 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн тус товхимолд оруулах мэндчилгээний үг, зурган мэдээллийг нэгтгэж хэвлэлт хариуцсан этгээд (Наранхүү-80750750)-д 2024.01.23-ны өдөр цахим хэлбэрээр хүргүүлсэн.<br><br>6. Нэгжийн даргыг төрийн цахим үйлчилгээ, нийтийн мэдээллийн дэд бүтцийн хөгжлийн хэрэгжилт, яамны үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээллийг тухай бүр боловсруулж, түүний ажилд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж байна. | | |
| 11 | ***Арга хэмжээ 4.2.***<br>Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй боловч цаг үеийн ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэнэ. | Үүрэг даалгавар гүйцэтгэсэн байна. | 0 | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | 1. Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2024 онд худалдан авахаар төлөвлөсөн "Аймаг, орон нутгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн аж, ахуй нэгжид чиглэсэн нэгдсэн систем нэвтрүүлэх ЦХХХЯ/20240101026", "MacOS, IOS, Android үйлдлийн системд монгол бичгээр бичих нөхцөлийг бүрдүүлэх ЦХХХЯ/20240201029" "Хиймэл оюун ухаан (AI) болон машин-суралцаа (machine-learning)-ны алгоритмд суурилсан технологид ашиглагдах Монгол хэлний өгүүлбэр зүйн болон үг зүйн сан (Natural language processing)-гийн систем хөгжүүлэх ЦХХХЯ/20240103033", "Төрөлжсөн бүртгэлийн сангийн бүртгэл, мэдээллийн систем хөгжүүлэх ЦХХХЯ/20240103036" төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хорооны | 01.15 | 12.15 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нарийн бичгээр томилогдон дараах ажлыг хийж гүйцэтгэсэн:<br>1. Дээрх 4 төслийн тендерийн баримт бичгийг боловсруулан захиалагчаар батлуулж, нийт 9 удаагийн хурлаар, 5 удаа тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 15 компанаас ирүүлсэн тендерийг урьдчилан үнэлж, үнэлгээний хороонд танилцуулан тэмдэглэл үйлдэж, 17 удаагийн мэдэгдлийг тендерт оролцогчдод хүргүүлсэн.<br><br>2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны "Эцэг, эхийн зөвлөл"-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 14 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Мөн тус батлагдсан төлөвлөгөөний хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр "Цахим орчинд гэр бүлээ хамгаалья" сэдэвт гэр бүлийн өдөрлөгийг удирдан зохион байгуулсан.<br><br>3. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/38 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2024 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд туссан "Хиймэл оюун ухаан, сансрын технологийн үзүүлэн бүтээх ЦХИХХЯ/20240603194" дугаартай төслийн ажлын даалгавар, "Гэрээ байгуулах, зардал гаргах тухай" Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төслийг тус тус боловсруулж, уг тендерийг зохион байгуулж, гэрээ байгуулж, гүйцэтгэлийг хүлээн авсан.<br><br>3. Ухаалаг Засаг 2 төслийн хүрээнд хэрэгжих "2.2.6 Үүлэн тооцооллын үйлчилгээг ашиглах судалгаанд ТЭЗҮ хийх зөвлөх үйлчилгээ", "2.2:6 Үүлэн тооцооллын үйлчилгээг ашиглах судалгаанд ТЭЗҮ хийх зөвлөх үйлчилгээ", 1.1.3 "Цахим шилжилтийг хийхэд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шаардлагатай дүрэм журмуудын хийдэл, зөрчлийг тогтоож, санал боловсруулах зөвлөх үйлчилгээ"-ний тендерийг үнэлэх үнэлгээний хорооны хуралд 12 удаа сууж, нийт 11 байгууллагаас ирүүлсэн мэдээллийг үнэлсэн.<br><br>5. онгол хэлний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь "цахим орчинд монгол хэл, бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх" гэж, 15.1.3-т "энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагын баталсан кирил болон үндэсний бичгийн хооронд харилцан хөрвүүлэг хийх, зөв бичих дүрмийн алдаа хянах болон бусад холбогдох программын хэрэглээг нэмэгдүүлэх, цахим орчинд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах" гэж тус тус зааны дагуу кирил бичгээс үндэсний бичиг рүү хөрвүүлэх программ хангамжийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд холбогдох судалгааг хийж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл ажлын албатай хамтран "Монгол бичгийн алдаа шалгагч, хөрвүүлэгч цахим систем бүтээхэд шаардлагатай дата сангийн судалгаа бүрдүүлэлт хийх, системийн бүрэн ажиллагаатай вэб хуудас программ"-ыг шууд худалдан авах боломжийг судалж байна. | | |
| 12 | ***Арга хэмжээ 4.3.***<br>Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлт, тэдгээр хамаарах дэмжих систем, сангийн удирдлагын тогтолцоо, холбогдох, дүрэм, журам, зохицуулалтын хэрэгжилтийг хангахад өөрийн хариуцсан асуудлын чиглэлээр мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлнэ. | Тухай бүр | 0 | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | 1.Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас "Төрийн албаны хүний нөөцийн бодлогыг дэмжих систем"-ийг хэрэглээнд нэвтрүүлэх гэж байгаатай холбогдуулж, тус системийг хэрэглээнд нэвтрүүлэхэд анхаарах зөвлөмжийг боловсруулж, хүргүүлсэн.<br><br>2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Нээлттэй эхийн программ хангамж (Open source software)-ийн талаар тайлбар, мэдээлэл бэлтгэн албан бичгээр хүргүүлсэн. Мөн хэрэгжүүлж байгаа төсөл хүлээн авахтай нь холбогдуулж,уулзалт | 01.15-06.15 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлсэн.<br><br>3. Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаа, цахим шилжилтийг эрчимжүүлэх багц хуулийн хүрээнд төрийн 54, хувийн хэвшлийн 3 байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу холбогдох мэдээллийг цаг тухайд нь боловсруулж, албан бичгээр болон цахим шуудангаар хүргүүлж шийдвэрлэсэн. | | |
| **Зорилт 5. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ"** | | | | | | | |
| 13 | ***Арга хэмжээ 5.1.***<br>Хариуцсан чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. | Өөрийн хариуцсан чиглэлээр болон ЦХБХЗГ-ын хариуцах асуудлын хүрээнд холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн баримт, бусад холбогдох материалын тоо | 0 | Хэрэгжилтээр | Хариуцсан асуудлын хүрээнд болон ЦХБХЗГ-т хамаарах асуудлаар дараах үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангаж, тухай бүр тайлан, мэдээ боловсруулан ажилласан. Үүнд:<br>1. Монгол Улсын Засгийн газрын тогтоол, хурлын тэмдэглэл, Ерөнхий сайдын Захирамж, албан даалгаврын биелэлтийг сар бүр гаргаж, тогтоосон хугацаанд ТЗУГ-т хүргүүлж байна. Тодруулбал:<br>• **2022** онд Засгийн газрын 15 тогтоолын хүрээнд 18 үүрэг, **2023** онд 22 тогтоолын хүрээнд 27 үүрэг, **2024** онд 9 тогтоолын хүрээнд 14 үүрэг;<br><br>• **2022** онд Засгийн газрын хуралдааны 31 тэмдэглэлийн хүрээнд 48 үүрэг, **2023** онд 35 тэмдэглэлийн хүрээнд 61 үүрэг, **2024** онд 8 тэмдэглэлийн хүрээнд 8 үүрэг;<br><br>• **2022** онд Ерөнхий сайдын 14 захирамжийн хүрээнд 17 үүрэг, **2023** онд 12 захирамжийн хүрээнд 13 үүрэг, **2024** онд 2 захирамжийн хүрээнд 2 үүрэг; | 01.15-06.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • **2022** онд Ерөнхий сайдын 6 албан даалгаврын хүрээнд 18 үүрэг, **2023** онд 1 албан даалгаврын хүрээнд 1 үүрэг, **2024** онд 1 албан даалгаврын хүрээнд 4 үүрэг;<br><br>• Төрийн бүтээмжийн үндэсний хорооны хуралдааны тэмдэглэлээр 3 үүрэг тус тус авч, хэрэгжилтийн тайланг боловсруулсан.<br><br>2. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан ажил, арга хэмжээний биелэлтийг хариуцах асуудлын хүрээнд, тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох газар, нэгжид тухай бүр хүргэн ажилласан.<br><br>3. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас "Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн хилийн чанад дахь Монгол иргэдийн төлөөлөлтэй хийсэн уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-ний хүрээнд хариуцан хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний биелэлт, УИХ-ын байнгын хорооны 1 болон 5 дугаар тогтоол, Нээлттэй засгийн түншлэлийн хэрэгжилтийн тайлан болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн тайланг тухай бүр боловсруулан холбогдох газар, нэгжид хүргүүлсэн.<br><br>4. Газрын 2024 оны I дүгээр улирал болон эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн боловсруулсан. | | |
| 14 | ***Арга хэмжээ 5.2.***<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт | Архивт хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо | 0 | Хэрэгжилтээр | Аймаг, орон нутгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн, аж ахуйн нэгжид чиглэсэн нэгдсэн систем нэвтрүүлэх-ЦХХХЯ/20240101026 дугаартай төслийн тендер шалгаруулалттай холбоотой баримт, материалыг Архив, албан хэрэг | 06.05-06.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | бичгийг хугацаанд нь бүрэн архивлана. | | | | хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу нэгтгэж, архивд хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон. | | |
| 15 | ***Арга хэмжээ 5.3.*** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэнэ. | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо | 0 | Хэрэгжилтээр | Арилжааны банкууд и-Монголын лавлагаагаар үйлчлүүлэхгүй байгаа тухай 3 иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу холбогдох судалгаа (Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк, Хаан банк)-г хийж, гомдол гаргасан 3 иргэнд тайлбар, мэдээлэл өгсөн. Мөн төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэхтэй холбоотой 4 санал, хүсэлтэд хариу өгч шийдвэрлэсэн. | 01.15-06.15 | 100 |
| 16 | ***Арга хэмжээ 5.4.*** Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь чанартай гүйцэтгэх, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. | Өгсөн үүрэг даалгаврын тоо | 0 | Хэрэгжилтээр | 1. Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралын урилгаар Бүгд Найрамдах Казакстан Улсын Цахим хөгжил, инновац, сансрын аж үйлдвэрийн яамны тэргүүн дэд сайд ноён Тулеушин Каныш тэргүүтэй төлөөлөгчид 2024 оны 4 дүгээр сарын 29-нөөс 5 дугаар сарын 02-ны хооронд Монгол Улсад ажлын айлчлал хийхээр төлөвлөсөнтэй холбогдуулж, айлчлалын бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн:<br>Салбарын болон төрийн 6 байгууллагын төлөөлөл нийт 40 гаруй ажилтан, албан хаагчдад Казакстан Улсын цахим шилжилтийн талаарх сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулахад Гадаад харилцааны хэлтэстэй хамтран ажилласан. Мөн тус айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, тус яамны сайдаар батлуулсан.<br><br>2. НҮБ-ын Эдийн Засаг, Нийгмийн хамтын ажиллагааны асуудал хариуцсан газар (UNDESA)-тай хамтран зохион байгуулсан “Монгол Улсын Үндэсний өгөгдлийн засаглалын тогтолцоо болон дижитал засаглал” сэдэвт Олон Улсын хурлыг 2024 оны 12 дугаар сарын 3, 4-ний өдрүүдэд | 04.25-04.29 | 100 |

| | | | | | БТГ-тай хамтран зохион байгуулсан. Тус хуралд төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагын удирдах болон ахлах албан тушаалтай нийт 78 төлөөлөл оролцож, оролцогчдоос гаргасан санал, зөвлөмжид үндэслэн бодлогын зөвлөмжийн төсөл боловсруулсан. | | |
|---|---|---|---|---|---|---|---|

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Хариуцсан ажлын чиглэлээр олон улсаас зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцно. | Оролцсон сургалт, хурал, семинарын тоо-2 | 0 | Оролцсон сургалт, хурал, семинарын тоо-1 | Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Ухаалаг засаг 2" төслийн хүрээнд Дэлхийн банк талаас “Төрийн цахим үйлчилгээний стандарт” сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан | 06.11 | 100 |
| 2. | Дотоодод зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцно. | Оролцсон сургалт, хурал, семинарын тоо-2 | 0 | Оролцсон сургалт, хурал, семинарын тоо-1 | Тунгаахуй өгөгдлийн урлан болон Паблик Лаб Монголиа хамтран Тогтвортой хөгжлийн зорилтын 11 хүрээнд Тэгш хүртээмжтэй хот ба Нээлттэй өгөгдөл сэдвээр 2 дахь жилдээ хамтран зохион байгуулсан ““Тэгш хүртээмжтэй хот ба Нээлттэй өгөгдөл” сургалтад хамрагдсан. | 03.04 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч ..........Болор-Эрдэнэ / Ч.Болор-Эрдэнэ/ 2024 оны 12 сарын 10